



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/456/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a> Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:undarmaam@audit.gov.mn">undarmaam@audit.gov.mn</a> Аудитор: Л.Одонтуяа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:Odontuyal@audit.gov.mn">Odontuyal@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт.



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Баян, 02, 2х № 01 | 225

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ  
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
М.ГАНЖИГҮҮР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Татварын багц хуулийг таниулах сургалт зохион байгуулахад 41,297.4 мянган төгрөг, сурталчилгааны видео шторк, контент бэлтгэхэд 21,900.0 мянган төгрөг, тараах материал QR наалт хэвлүүлэхэд 79,582.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

#### Аудитын гол асуудал

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны А/595 дугаар захирамжийг үндэслэн 2024 оны татвар хураалтад идэвх зүтгэлтэй ажилласан хэлтсийн ажилтнуудад 25,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100.0 хувиар үнэлүүлсэн байна.

Улс болон орон нутгийн төсөвт 427,207,690.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 441,954,652.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 3.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

СЭМЖЭГЭЙН ГАРЗГААРИЛ

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,467,280.27</b>	<b>61,768,304.85</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>35,467,280.27</b>	<b>61,768,304.85</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>35,467,280.27</b>	<b>61,768,304.85</b>
35410	Бичиг хэргийн материал	7,504,129.25	16,796,010.08
35420	Аж ахуйн материал	14,516,393.02	26,461,836.77
35470	Бусад хангамжийн материал	13,446,758.00	18,510,458.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,033,201,986.27</b>	<b>1,063,321,062.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,033,201,986.27</b>	<b>1,063,321,062.53</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,008,292,205.89</b>	<b>1,040,018,917.62</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,091,515,016.05	1,091,515,016.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-140,907,620.90	-160,404,528.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,000,000.00	-38,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	403,805,396.04	438,900,296.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	-384,471,120.54	-395,674,589.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,312,347.69	108,322,347.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	-57,346,441.87	-63,440,616.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,829,376.44	31,444,376.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,444,747.02	-10,643,384.22
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>24,909,780.38</b>	<b>23,302,144.91</b>
39301	Програм хангамж	9,698,239.61	10,101,973.61
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,932,599.23	-7,943,968.70
39303	Бусад биет бус хөрөнгө	21,144,140.00	21,144,140.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,068,669,266.54</b>	<b>1,125,089,367.38</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,068,669,266.54</b>	<b>1,125,089,367.38</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,068,669,266.54</b>	<b>1,125,089,367.38</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>1,393,712,222.43</b>	<b>1,393,712,222.43</b>
51101	Өмч: - төрийн	1,393,712,222.43	1,393,712,222.43
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-325,042,955.89</b>	<b>-268,622,855.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-452,233,607.95	-325,042,955.89
51220	Тайлант үеийн үр дүн	127,190,652.06	56,420,100.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,068,669,266.54</b>	<b>1,125,089,367.38</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,937,413,439.00</b>	<b>4,844,562,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>271,644,439.00</b>	<b>64,528,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>271,644,439.00</b>	<b>64,528,000.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.00	1,239,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	1,239,000.00
120010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	271,644,439.00	63,289,000.00

**Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,665,769,000.00</b>	<b>4,780,034,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,390,102,500.00</b>	<b>4,529,364,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,390,102,500.00	4,529,364,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>275,666,500.00</b>	<b>250,670,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,798,500.00	195,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,868,000.00	55,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,810,222,786.94</b>	<b>4,788,142,699.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,810,222,786.94</b>	<b>4,788,142,699.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,368,268,692.61</b>	<b>4,726,924,890.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,610,627,249.35</b>	<b>3,827,917,691.86</b>
210101	Үндсэн цалин	1,291,334,378.67	1,846,385,850.86
210102	Нэмэгдэл	467,243,149.02	685,882,005.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	177,418,071.45	268,724,000.00
210104	Урамшуулал	674,631,650.21	1,026,925,836.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>312,685,427.36</b>	<b>486,202,014.67</b>
210201	Тэтгэврийн даатгал	214,308,687.82	336,739,294.90
210202	Тэтгэмжийн даатгал	24,726,390.79	38,540,269.09
210203	ҮОМШ өвчний даатгал	19,674,520.77	18,986,334.91
210204	Ажилгүйдлын даатгал	4,854,137.28	18,387,223.40
210205	Эрүүл мэндийн даатгал	49,121,690.70	73,548,892.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,762,476.51</b>	<b>33,346,984.28</b>
210301	Гэрэл цахилгаан	19,240,360.97	19,952,279.69
210302	Түлш, халаалт	10,379,736.89	8,931,229.70
210303	Цэвэр, бохир ус	4,142,378.65	4,463,474.89
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>158,911,038.57</b>	<b>115,157,634.47</b>
210401	Бичиг хэрэг	93,350,101.60	74,562,975.71
210402	Тээвэр, шатахуун	15,940,000.00	16,068,570.55
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	19,602,531.44	19,210,984.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	488,843.72	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,529,561.81	4,745,103.44
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,764,899.04</b>	<b>45,716,200.00</b>
210604	Урсгал засвар	18,764,899.04	45,716,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>92,687,956.00</b>	<b>143,019,357.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,401,700.00	142,703,160.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,640.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,276.00	99,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0.00	194,921.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	43,340.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>140,829,645.78</b>	<b>75,565,007.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000.00	0.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	3,745,000.00	34,560,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	137,034,645.78	41,004,557.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>441,954,094.33</b>	<b>61,217,809.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>171,285,648.00</b>	<b>55,927,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,285,033.00	20,367,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,000,615.00	35,560,000.00

Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	270,668,446.33	5,290,109.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	270,668,446.33	5,290,109.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	127,190,652.06	56,420,100.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	127,190,652.06	56,420,100.84

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	3,665,769,000.00	4,780,034,800.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	3,665,769,000.00	4,780,034,800.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,390,102,500.00	4,529,364,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,390,102,500.00	4,529,364,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	275,666,500.00	250,670,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,798,500.00	195,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,868,000.00	55,500,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	3,664,739,100.00	4,772,200,166.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,664,739,100.00	4,772,200,166.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,222,785,005.67	4,710,982,356.86
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,610,627,249.35	3,834,236,020.31
210101	Үндсэн цалин	1,291,334,378.67	1,726,251,795.79
210102	Нэмэгдэл	467,243,149.02	724,781,100.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	177,418,071.45	251,340,092.87
210104	Урамшуулал	674,631,650.21	1,131,863,031.65
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	312,685,427.36	479,883,686.22
210201	Тэтгэврийн даатгал	214,308,687.82	333,323,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,726,390.79	36,639,999.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,674,520.77	18,320,194.89
210204	Ажилгүйдлийн даатгал	4,854,137.28	18,320,192.96
210205	Эрүүл мэндийн даатгал	49,121,690.70	73,279,998.87
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,762,476.51	33,346,984.28
210301	Гэрэл, цахилгаан	19,240,360.97	19,952,279.69
210302	Түлш, халаалт	10,379,736.89	8,931,229.70
210303	Цэвэр, бохир ус	4,142,378.65	4,463,474.89
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	107,815,989.45	95,163,609.05
210401	Бичиг хэрэг	66,829,920.00	57,203,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,560,000.00	15,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,597,531.45	19,290,609.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	159,800.00	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,668,738.00	2,400,000.00

Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,530,247.00	58,025,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	9,467,100.00
210604	Урсгал засвар	18,530,247.00	48,558,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	114,353,616.00	158,429,457.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,110,700.00	158,113,260.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,640.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,276.00	99,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0.00	194,921.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,010,000.00	51,897,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,960,000.00	51,897,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	441,954,094.33	61,217,809.14
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	171,285,648.00	55,927,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,285,033.00	20,367,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,000,615.00	35,560,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	270,668,446.33	5,290,109.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	270,668,446.33	5,290,109.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	1,029,900.00	7,834,634.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	1,029,900.00	7,834,634.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,029,900.00	7,834,634.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,029,900.00	7,834,634.00
223001	Бусад хөрөнгө	1,029,900.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	7,834,634.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-1,029,900.00	-7,834,634.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.00	0.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-452,233,607.95	0.00	941,478,614.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-452,233,607.95	0.00	941,478,614.48
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	127,190,652.06	0.00	127,190,652.06
C08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-325,042,955.89	0.00	1,068,669,266.54
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-325,042,955.89	0.00	1,068,669,266.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-325,042,955.89	0.00	1,068,669,266.54
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	56,420,100.84	0.00	56,420,100.84
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,393,712,222.43	0.00	-268,622,855.05	0.00	1,125,089,367.38

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,561,812,100.00</b>	<b>4,524,074,690.86</b>	<b>37,737,409.14</b>	<b>99.2%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,561,812,100.00</b>	<b>4,524,074,690.86</b>	<b>37,737,409.14</b>	<b>99.2%</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,498,437,100.00</b>	<b>4,493,146,990.86</b>	<b>5,290,109.14</b>	<b>99.9%</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,839,067,400.00</b>	<b>3,834,236,020.31</b>	<b>4,831,379.69</b>	<b>99.9%</b>
210101	Үндсэн цалин	1,710,121,100.00	1,726,251,795.79	-16,130,695.79	100.9%
210102	Нэмэгдэл	724,781,100.00	724,781,100.00	0.00	100.0%
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	251,340,100.00	251,340,092.87	7.13	100.0%
210104	Урамшуулал	1,152,825,100.00	1,131,863,031.65	20,962,068.35	98.2%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>479,883,700.00</b>	<b>479,883,686.22</b>	<b>13.78</b>	<b>100.0%</b>
210201	Тэтгэврийн даатгал	333,323,300.00	333,323,300.00	0.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	36,640,000.00	36,639,999.50	0.50	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,320,200.00	18,320,194.89	5.11	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	18,320,200.00	18,320,192.96	7.04	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	73,280,000.00	73,279,998.87	1.13	100.0%

**Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,377,800.00</b>	<b>33,346,984.28</b>	<b>30,815.72</b>	<b>99.9%</b>
210301	Гэрэл, цахилгаан	18,305,400.00	19,952,279.69	-1,646,879.69	109.0%
210302	Түлш, халаалт	9,838,400.00	8,931,229.70	907,170.30	90.8%
210303	Цэвэр, бохир ус	5,234,000.00	4,463,474.89	770,525.11	85.3%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,116,500.00</b>	<b>21,060,609.05</b>	<b>55,890.95</b>	<b>99.7%</b>
210401	Бичиг хэрэг	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,346,500.00	11,290,609.05	55,890.95	99.5%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	570,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,400,000.00	0.00	100.0%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>64,196,100.00</b>	<b>64,191,500.00</b>	<b>4,600.00</b>	<b>100.0%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,753,100.00	10,753,000.00	100.00	100.0%
210604	Урсгал засвар	53,443,000.00	53,438,500.00	4,500.00	100.0%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,795,600.00</b>	<b>51,428,191.00</b>	<b>367,409.00</b>	<b>99.3%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,112,000.00	51,111,994.00	6.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,400.00	99,276.00	124.00	99.9%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.0%
210807	Газрын төлбөр	562,200.00	194,921.00	367,279.00	34.7%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,000,000.00</b>	<b>9,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.0%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>63,375,000.00</b>	<b>30,927,700.00</b>	<b>32,447,300.00</b>	<b>48.8%</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,375,000.00</b>	<b>30,927,700.00</b>	<b>32,447,300.00</b>	<b>48.8%</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,815,000.00	20,367,700.00	32,447,300.00	38.6%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,560,000.00	10,560,000.00	0.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,561,812,100.00</b>	<b>4,524,074,690.86</b>	<b>37,737,409.14</b>	<b>99.2%</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,561,812,100.00</b>	<b>4,524,074,690.86</b>	<b>37,737,409.14</b>	<b>99.2%</b>
131001	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>4,561,812,100.00</b>	<b>4,524,074,690.86</b>	<b>37,737,409.14</b>	<b>99.2%</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	96	96	0	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0	100.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	97	97	0	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>250,670,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>250,670,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>225,670,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,103,000.00</b>
210401	Бичиг хэрэг	51,603,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>108,670,000.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>108,670,000.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,897,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,897,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>250,670,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>250,670,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	195,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,500,000.00

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 17,211.8 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

### Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг 3,959.0 мянган төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийг 3,959.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 616.2 мянган төгрөгөөр илүү тооцсон;
3. Даатгуулагчаас суутган тооцсон 4,936.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлүүлсэн;
4. Цалингийн зардлын данстын эдийн засгийн ангилал хооронд 7,699.8 мянган төгрөгийн гүйлгээг зөрүүтэй илэрхийлсэн.

Эдгээр нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 23,900.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 23,900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 23,900.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33,253.3 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас 23,900.0 мянган төгрөгийн бараа, материал худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлийн байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ худалдан аваагүй зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах хугацаа дуусч, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 78 нэр төрлийн 443,457.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцээгүй.

**Өгссөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг ангилан дахин үнэлж, бүртгэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан	1	3,959.0	1	3,959.0	1	3,959.0
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг илүү тооцсон	1	616.2	1	616.2	1	616.2
Даатгуулагчаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлүүлсэн	1	4,936.8	1	4,936.8	1	4,936.8
Цалингийн зардлын данстын эдийн засгийн ангилал хооронд залруулгын гүйлгээ хийсэн	1	7,699.8	1	7,699.8	1	7,699.8
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>17,211.8</b>	<b>3</b>	<b>17,211.8</b>	<b>3</b>	<b>17,211.8</b>

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас бараа материал худалдан авч, сургалт зохион байгуулж, өрөө түрээслэсэн.	1	23,900.0	1	23,900.0		
Элэгдэл дууссан 443,457.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй	1	0.0			1	0.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>23,900.0</b>	<b>1</b>	<b>23,900.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль, тогтоомжтой холбоотой</b>						
Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй.	1	90,373.6			1	90,373.6
Үндсэн ажил үүргээ гүйцэтгэсэн ажилтнуудад нэмэлт санхүүжилтээс дэмжлэг олгосон.	1	25,000.0			1	25,000.0
Сургалт сурталчилгаатай холбоотой зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй.	1	142,779.5			1	142,779.5
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>258,153.1</b>			<b>3</b>	<b>258,153.1</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 172/АУ231309

Улаанбаатар хот

НТАГ - 2025/4СБ/НА - СТЯ - Телз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас 23,900,000.00 (хорин гурван сая есөн зуун мянган) төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлийн байгууллагаас худалдан авалт хийгээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга М.Ганжигүүр, нягтлан бодогч Н.Долгорсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АУДИТОР

Л.ОДОНТУЯА

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043577